

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ НИСЛЭГТ
ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай ИНЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр баталсан 07/20 дугаар удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Дотоод аудитыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын /ИКАО/ протокол асуулт AIR 5.001-AIR-5.453 –ын дагуу нийт 120 асуултад хийсэн болно.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны менежер П.Батсайхан 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ. Жич: 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр ИНЕГ-ын хариуцлагатай эргүүлээр ажилласан тул төлөвлөгөөнөөс 1 өдөр хойшилсон болно.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн болон ИКАО-ын протокол асуултын хүрээнд тус хэлтэс үйл ажиллагаагаа хэрхэн хэрэгжүүлж, холбогдох стандартыг мөрдөж ажилласан эсэхийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Монгол Улс нь ИКАО-ын 6, 7, 8 болон 16 дугаар хавсралтуудын нислэгт тэнцэх чадварын шаардлагуудыг өөрийн улсын хүрээнд хэрэгжүүлэх хэмжээний нислэгт тэнцэх чадварын хууль, дүрмүүдийг боловсруулан нийтэлсэн байна.

Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн бүх үүрэг хариуцлага, үйл ажиллагаа нь нарийвчлан тодорхойлогдсон байна.

Монгол Улс нь НТЧ-ын байцаагчийн мэргэшил, дадлага туршлагад тавигдах доод шалгуурыг тогтоосон байна.

НТЧ-ын байцаагч нар нь ямар төрлийн сургалтад хамрагдсан байх талаар тодорхой тусгасан сургалтын хөтөлбөрийг НТЧХ боловсруулсан байна. Гэвч сайжруулах шаардлагатай.

НТЧ-ын байцаагч нар нь улсын бүртгэлийн гэрчилгээ олгогдсон агаарын хөлгийг зохион бүтээсэн байгууллагын бичиг баримт болон НТЧ-ын байнгын хяналтын талаарх мэдээллээр хангагдах боломжтой байна.

Монгол Улс нь бүртгэлийн гэрчилгээ олгох, түүний дотор олон улсын чиглэлийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт бүртгэлийн гэрчилгээ заавал байх шаардлагыг багтаасан дүрмүүдийг боловсруулан нийтэлсэн байна. Бүртгэлийн гэрчилгээ нь ИКАО-ын хавсралт 7 дээрх загварын шаардлагыг хангаж байна.

Хэрэв тухайн улсад агаарын хөлөг түүний эд ангиудыг импортоор оруулж ирэхэд тавьдаг тусгай шаардлагууд бий бол хэлэлцэн тохирогч улсуудад дээрх тусгай шаардлагуудыг шинэчлэн хэрэглэх бололцоогоор хангаж өгч байна. Гэвч дэлгэрэнгүй журам боловсруулах ёстой.

НТЧ-ын хэлтсээс тухайн Маягийн агаарын хөлгийн анхны НТЧ гэрчилгээг олгох журмыг хэрэгжүүлж хэвшсэн байна.

Монгол Улс нь ICAO Annex 16, Volume I-ийн дуу чимээний гэрчилгээний шаардлагыг бүх агаарын хөлөг (онгоц) хангах тухай дүрмүүдийг боловсруулан нийтэлсэн байна.

НТЧ гэрчилгээг тодорхой тогтсон үечлэлээр шинэчилж байх эсхүл хугацаагүй олгох тухай дүрмээр тодорхойлж өгсөн, мөн тухайн улсаас олгосон НТЧ-ын гэрчилгээнд ICAO Annex 8-ын шаардлагыг хангах бүх мэдээлэл агуулагдсан байна.

Агаарын хөлгийн жин ба төвлөрөлтийн мэдээг тогтоосон үечлэлээр хийхийг ИНД-ээр шаарддаггүй боловч уг ажлыг тогтмол хийхийг заасан ИНЕГ-ын дарга тушаал батлагдсан байна.

Зохион бүтээгч улсаас гаргасан заавал биелүүлэх НТЧ-ын хадгалалтын мэдээллийн (mandatory continuing airworthiness information) шаардлагыг хангаж ажиллах тухай дүрмүүдийг боловсруулан нийтэлсэн байна.

НТЧ-ын хэлтэс нь Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох явцад MEL, ETOPS, RVSM, RNP, CAT II болон CAT III-ын баталгаажуулалттай холбоотой үйл ажиллагааны онцлог нөхцөлүүдийг хянах болон баталгаажуулах процесст оролцож байна.

Хэрэв Монгол Улс нь Чикагогийн конвенцийн Артикл 83бис-ийн дагуу ямар нэгэн гэрээ байгуулсан бол бусад улстай Артикл 83бис-ийн дагуу үйл ажиллагаа болон үүрэг хариуцлага шилжүүлэх тухай дэлгэрэнгүй журам боловсруулах шаардлагатай байна.

НТЧХ нь илэрсэн дутагдал болон аюулгүй ажиллагааны зөрчлүүдийг хугацаанд нь засахын тулд албадлагын арга хэмжээ авах болон түүнд хүрэх хүртэл тохирсон засч залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тухай баримтжуулсан процессыг хэрэгжүүлсэн байна.

НТЧХ нь найдвартай ажиллагааны хөтөлбөрийг хянах ажил хийдэг байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Нисэхийн аюулгүй ажллагааны хяналт, зохицуулалтын албанд 5 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА